



I-III/2021

Тархаасан: 2021 оны 6 дугаар сарын 10



Улсын нийт гадаад өр 32.5 тэрбум ам.доллар байна

Улсын нийт гадаад өр 2021 оны эхний улиралд 32.5 тэрбум ам.доллар болж, өмнөх оны мөн үеэс 2.0 (6.7%) тэрбум ам.доллар, өмнөх улирлаас 325.1 (1.0%) сая ам.доллороор өссөн байна.

Нийт гадаад өрийг салбараар авч үзэхэд нийт өрийн 36.2 хувь буюу 11.8 тэрбум ам.доллар нь шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг, 26.0 хувь буюу 8.5 тэрбум ам.доллар нь Засгийн газрынх, 25.9 хувь буюу 8.4 тэрбум ам.доллар нь бусад салбарынх, 6.7 хувь буюу 2.2 тэрбум ам.доллар нь Төв банкных, 5.1 хувь буюу 1.7 тэрбум ам.доллар нь Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх байна.

Улсын нийт гадаад өр өмнөх оны мөн үеэс өсөхөд шууд хөрөнгө оруулалт, компани хоорондын зээллэг 1.1 (10.4%) тэрбум ам.доллар, Засгийн газрынх 1.2 (16.8%) тэрбум ам.доллар, Төв банкных 0.2 (11.0%) тэрбум ам.доллар, бусад салбарынх 23.4 (0.3%) сая ам.доллараар өсжээ. Харин Төв банкнаас бусад хадгаламжийн байгууллагынх 0.5 (24.5%) тэрбум ам.доллараар буурчээ.

Хүснэгт 1. Улсын нийт гадаад өр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлт	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021*I-III	<u>2021*I-III</u> <u>2020 I-III</u>
	сая ам.доллар				хувь
Нийт гадаад өр	27 905.5	29 521.8	30 461.1	32 487.0	106.7
Засгийн газар ¹	7 242.4	7 262.3	7 235.9	8 450.5	116.8
Төв банк	2 136.6	2 072.4	1 973.5	2 191.3	111.0
Хадгаламжийн байгууллага (Төв банкнаас бусад)	2 346.9	2 393.4	2 212.5	1 669.4	75.5
Бусад салбарууд	7 944.4	8 384.6	8 381.0	8 404.4	100.3
Шууд хөрөнгө оруулалт: Компани хоорондын зээллэг	8 235.2	9 409.1	10 658.3	11 771.4	110.4

Эх үүсвэр: Монголбанк

¹ Зах зээлийн үнэлгээ, аккруэл суурьд үндэслэсэн дүн

Засгийн газрын нийт өр 2021 оны эхний улиралд 27.3 их наяд төгрөг болж, өмнөх оны мөн үеэс 2.8 (11.3%) их наяд төгрөгөөр өсөж, өмнөх улирлаас 0.6 (2.0%) их наяд төгрөгөөр буурсан байна. Засгийн газрын нийт өр өмнөх улирлаас буурахад засгийн газрын гадаад өр 0.5 (1.8%) их наяд доллараар буурсан нь голлон нөлөөлсөн байна.

Засгийн газрын нийт өр өмнөх оны мөн үеэс өсөхөд Засгийн газрын дотоод өр 222.8 (16.4%) тэрбум төгрөг, Засгийн газрын өрийн баталгаа 91.3 (8.7%) тэрбум төгрөг, барих-шилжүүлэх төрлийн концесс 115.2 (12.0%) тэрбум төгрөгөөр буурсан хэдий ч Засгийн газрын гадаад өр 3.2 (15.2%) их наяд төгрөгөөр өссөн нь нөлөөлжээ.

Хүснэгт 2. Засгийн газрын нийт өр, жил бүрийн эхний улирлын байдлаар

Үзүүлэлтүүд	2018 I-III	2019 I-III	2020 I-III	2021*I-III	$\frac{2021^*I-III}{2020 I-III}$
	тэрбум төгрөг				хувь
Засгийн газрын нийт өр	21 482.7	22 350.4	24 552.1	27 332.7	111.3
Засгийн газрын дотоод өр (өрийн хэрэгслээр)	2 706.0	1 533.5	1 359.4	1 136.6	83.6
Үнэт цаас	2 706.0	1 533.5	1 359.4	1 136.6	83.6
Засгийн газрын гадаад өр ² (өрийн хэрэгслээр)	16 636.7	18 927.9	21 180.1	24 390.0	115.2
Үнэт цаас	7 288.2	7 631.4	8 050.1	8 354.4	103.8
Зээл	9 348.5	11 296.4	13 130.0	16 035.6	122.1
Засгийн газрын өрийн баталгаа	1 549.6	1 084.6	1 055.5	964.2	91.3
Барих- Шилжүүлэх төрлийн концесс	590.4	804.4	957.1	841.9	88.0

Эх үүсвэр: Сангийн яам,

²Нэрлэсэн дүнгээр илэрхийлсэн дүн

Засгийн газрын нийт өрийн 24.4 их наяд төгрөг буюу 89.2 хувь нь гадаад өр, 1.1 их наяд төгрөг буюу 4.2 хувь нь дотоод өр, 1.0 их наяд төгрөг буюу 3.5 хувь нь Засгийн газрын өрийн баталгаа, 0.8 их наяд төгрөг буюу 3.1 хувь нь барих-шилжүүлэх төрлийн концесс байна.

Зураг 1. Засгийн газрын өрийн бүтэц, дүнд эзлэх хувь, жил бүрийн эхний улирлын байдлаар



Эх үүсвэр: Сангийн Яам

Засгийн газрын нийт өрөөс 2021 оны эхний улиралд үндсэн төлбөрт 315.3 тэрбум төгрөг, хүүгийн төлбөрт 132.4 тэрбум төгрөг төлөгдсөн байна. Үндсэн төлбөрийн төлөлт 2021 оны эхний улиралд өмнөх оны мөн үеэс 74.6 (31.0%) тэрбум төгрөгөөр өсөж, хүүгийн төлбөр 52.9 (28.5%) тэрбум төгрөгөөр буурчээ.

Ойлголт, тодорхойлолт:

Улсын нийт гадаад өр: Засгийн газар, орон нутаг, Монголбанк болон Монгол Улсад бүртгэлтэй аж ахуйн нэгж, иргэдээс Монгол Улсад бүртгэлгүй, эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг ойлгоно. Үүнд гадаад зээл, өрийн бичиг, харилцах хадгаламж, худалдааны зээл болон урьдчилгаа болон бусад өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийг хамруулна.

Засгийн газрын дотоод өр: Өрийн хэрэгслээр үүсгэж, Монгол Улсын Засгийн газраас бусдын өмнө хүлээсэн төлбөрийн үүргийг ойлгоно.

Засгийн газрын гадаад өр: Монгол Улсын Засгийн газрын эдийн засгийн харьяат бус аливаа этгээдэд төлөх өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийн үүргийг ойлгоно. Үүнд гадаад зээл, өрийн бичиг, дотоод үнэт цааснаас эдийн засгийн харьяат бус этгээдийн эзэмшиж буй дүн болон бусад өрийн хэрэгслээр үүсгэгдсэн төлбөрийг хамруулна.

Засгийн газрын өр: Засгийн газрын дотоод өр, засгийн газрын гадаад өрийн нийлбэр байна.

Концесс: Улсын болон орон нутгийн төсвөөс эргэн төлөгдөх нөхцөлтэй Барих-шилжүүлэх төрлөөр байгуулсан концессын гэрээний хүрээнд гарсан ашиглалтыг үндэслэн бүртгэсэн дүнг хэлнэ. Концесс эзэмшигч концессын зүйлийг өөрийн болон өөрийн боломжоор олсон хөрөнгөөр барьж ашиглалтад оруулан, гэрээнд заасан нөхцөлөөр төрийн болон орон нутгийн өмчлөлд шилжүүлэх нөхцөлтэй концессын гэрээ юм.

Эх үүсвэр: Сангийн яам

Ангилал, код: Эдийн засгийн секторын ангилал

Тайлбар:

Мэдээлэл авах линкүүд:

<http://www.nso.mn/>

<http://www.1212.mn/>



Дараагийн мэдээ тархаах хуваарь: 2021 оны 9 дүгээр сарын 15

Хавсралт:

*Эдийн засгийн статистикийн газрын
Статистикч Ч.Мөнхтуул
Утас (976-51)-261565*

*Эдийн засгийн статистикийн газрын
дарга Э.Эрдэнэсан
Утас (976-51)-266414*